

АЖЛЫН ДААЛГАВАР **/ЧИГЛЭЛ-010/**

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нийгэм,
эдийн засгийн нөлөөллийн судалгааны ажил хийх

ҮНДЭСЛЭЛ:

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг сайжруулах нь нийгмийн ухамсар, хариуцлага болон хуулийн зохицуулалтаас гадна эдийн засгийн үр дагавартай шууд холбоотой байдаг. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас үүссэн эдийн засгийн хохирол нь байгууллагыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулахад чухал түлхэц болдог байна.¹

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын статистик мэдээллээр үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас өдөр бүр 7600 гаруй хүн нас барж, сая гаруй хүн гэмтэж, өвчилж байна.² Хүний амь нас, эрүүл мэндэд учирч байгаа хохирлын хажуугаар нийгэм болон эдийн засагт үзүүлж буй нөлөөлөл асар их юм. Эдийн засгийн хүрээнд л гэхэд ОУХБ-ын хийсэн тооцооллоор үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас учирч байгаа хохирол дэлхийн хэмжээнд дотоодын нийт бүтээгдэхүүний 4 ба түүнээс дээш хувьтай тэнцэж байна.³ Эдийн засгийн хохирлын хэмжээ асар өндөр байгааг харж болно.

Нийгэмд болон тухайн ажилтны амьдрал, гэр бүлд, байгууллагад асар их зардал, нөлөөлөл үзүүлдэг байна. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний үзүүлж байгаа зардлыг Хэйдрихийн “мөсөн уул” загвартай⁴ зүйрлэвэл шууд харагдаж байгаа хохирол, зардал буюу мөнгөн хэлбэрээр шууд тооцох боломжтой зардал бол мөсөн уулын ердөө харагдах хэсэг юм. Үүний цаана шууд бус буюу ажилтны сэтгэл санаа, байгууллагын имидж, хэрэглэгчийн харилцаа зэрэгт асар их сөрөг нөлөө үзүүлж, зардал, хохирол гардаг байна.

Иймээс үйлдвэрлэлийн осол, гэмтэл, өвчлөлийн улмаас учрах зардлыг нарийн тооцож харах нь урьдчилан сэргийлэх арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, аж ахуйн нэгж, байгууллагуудаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангахад зарцуулсан зардлын үр ашгийг таниулахад чухал ач холбогдолтой юм.

ЗОРИЛГО:

Энэхүү судалгааны ажлын үндсэн зорилго нь урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр өгөөж буюу үйлдвэрлэлийн осол, гэмтэл, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлснээр, хөрөнгө зарцуулснаар хүртэх үр ашгийг судалгаа, шинжилгээний үндсэн дээр тодорхойлж гаргахад оршино.

ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ЧИГЛЭЛ:

Судалгааны ажлын хүрээнд дараахь ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

¹ Европын холбоо. (2011) Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нийгэм-эдийн засгийн үр нөлөө

² ОУХБ. (2017). Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэлхийн өдөрт: Ажилтны амь нас, эрүүл мэндийг тоо, мэдээлэл хэрхэн хамгаалж чадах вэ.

³ ОУХБ. (2012). Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улс орны бүртгэл, мэдээлэл, дүн шинжилгээг сайжруулах нь.

⁴ Heinrich, H.W (1932). Үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, шинжлэх ухаанч хандлага.

1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого болон мэргэжлээс шалтгаалсан өвчний хувь хүн, аж ахуйн нэгж байгууллага, нийгэмд үзүүлэх эдийн засгийн нөлөөлөл, гол үр дагавар, зардлыг тодорхойлох;
2. Зардлын тооцоог ажил олгогч болон ажилтнаар өвчлөл, гэмтлийн төрөл, ослын зэрэг, осолдогчийн байдал /нас, хүйс, гэр бүлийн байдал, ажил мэргэжил г.м/ зэрэгтэй уялдуулан тооцох ;
3. Зардлын төрөл, хэмжээ /орлого алдах, эрүүл мэндийн үйлчилгээ авсан зардал зэрэг/ түүнийг нийгэм, эдийн засгийн хувьд хэрхэн үнэлэх, тооцох;
4. Нийгмийн үр дагавар болон эдийн засгийн зардлын хоорондын холбоо, хамаарлыг тодорхойлох;
5. Судалгааны үр дүнд үндэслэн санал, зөвлөмж боловсруулах.

ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас нь зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад санал авна. Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэгч нь Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт судалгааны арга зүй, судалгааны сонгосон нэгжийг урьдчилан танилцуулж, зөвшилцөнө. ХХБХЗГ-аас судалгаа хийх байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллана.

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

Судалгааг гүйцэтгэгчид дараахь шаардлага тавигдана.

1. Эдийн засгийн мэргэжлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй байх,
2. Хөдөлмөрийн салбарт 8-аас дээш жил ажилласан, эрдэм шинжилгээний ажил хийж байсан туршлагатай байх,
3. Хариуцсан ажлаа чанарын өндөр түвшинд гүйцэтгэх, богино хугацаанд ачаалалтай ажиллах, удирдан зохион байгуулах чадвартай байх,
4. Байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэдлэгтэй, зардал-үр өгөөжийн тооцоолол, судалгаа хийж байсан ажлын туршлагатай байх,
5. Хөдөлмөрийн харилцаа, цалин хөлс, нийгмийн даатгалын чиглэлээр ажиллаж байсан, энэ чиглэлээр судалгаа хийж байсан туршлагатай байх.

ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА:

- 2019 оны 12 дугаар сарын 10-ны дотор бүрэн хийж гүйцэтгэсэн байна.